



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/67

Бор-Өндөр сум

**Засаг даргын нөөцөөс хөрөнгө
зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хот дахь Хэнтий аймгийн Залуучуудын холбооноос уламжлал болгон зохион байгуулдаг "АЛТАН ЦОМ"-2025 спортын наадамд 1,000,000 (нэг сая), Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойг угтсан "Эмчээ сонсьё" хүндэтгэлийн арга хэмжээний зардалд 681,575 (зургаан зуун наян нэгэн мянга таван зуун далан тав), "Дэлгэр жаргалантын дээдийн өлзийт бичиг, соёл мину" уриан дор зохион байгуулагдах бичиг үсгийн баярын хүрээнд зарласан "Сэцэн ханы бичиг" бүтээлийн үзэсгэлэнгийн арга хэмжээнд оролцход 6,000,000 (зургаан сая) нийт 7,681,575 (долоон сая зургаан зуун наян нэгэн мянга таван зуун далан тав) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 7,681,575 (долоон сая зургаан зуун наян нэгэн мянга таван зуун далан тав) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих хууль, дүрмийн дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ